



### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 09

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүгнэлт хүргүүлэх тухай" 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 90 тоот, Туул голын сав газрын захиргааны даргын 2017 оны 5 дугаар сарын ..... -ний өдрийн А- ..... тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Ус ашиглалтыг зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлөөлж тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Гацуурт ХХК-ийн байр, улсын бүртгэлийн 9011025150 тоот гэрчилгээ, 2615797 тоот регистрийн дугаартай "ГБНБ" ХХК-ийн захирал Л.Чинбат нар ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2017 оныг дуустал байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-008998 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Баруун Захцагийн алтны шороон орд"-ын үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд болон хүн амын унд, ахуйн зориулалтаар усны нөөцийг ашиглана.

2.1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.3-т заасны дагуу 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 122'187 м<sup>3</sup> элс угаахад 488'748 м<sup>3</sup>/жил

2.2.1. Унд-ахуйд: 2110 м<sup>3</sup>/жил

2.2.2. Нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ: 225'280 м<sup>3</sup>/жил

2.2.3. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжинд: 700 м<sup>3</sup>/жил

2.2.4. Зам, талбайн усалгаанд: 3264 м<sup>3</sup>/жил

2.3. *Усны чанар, найрлага:* ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнд шинжлүүлсэн ахуйн худгийн ус нь магнийн ионы агууламжаар ундны усны стандарт MNS900:2010-д заасан хэмжээнээс их, тунгаах нуурын уснаас авсан химийн шинжилгээний үзүүлэлт нь MNS4943:2011 стандартын шаардлага хангасан байна.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Технологийн хэрэгцээний усыг Туул голоос сувгаар татсан уснаас, унд, ахуйн усыг гүний худгаас авч ашиглана.

Технологийн ус авч буй цэг /насос/-ийн байршил:

N 48° 15' 22.8", E 104° 20' 44.2"

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Ахуйн худгийн байршил  
N 48° 15' 25.3", E 104° 21' 00.2"

2.4.2. *Барилга байгууламж*: Үйлдвэрлэлийн ажиллагаанд 428 мян.м<sup>3</sup> багтаамжтай эргэлтийн усан сан, 200 мм-ийн диаметр бүхий 350 м урттай ус татах полимер хоолой ашиглана.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк*: Скрин маркийн зэрэгцээ байрласан 80-120 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай 3 ш угаах төхөөрөмжтэй.

2.4.4. *Насосны хүчин чадал*: Унд ахуйн худагт Шинэ Зеланд улсад үйлдвэрлэсэн Perinks 125 маркийн насос, технологийн хэрэгцээний усыг дамжуулан шахахад 315 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай Perinks YD 39860 маркийн 2ш, G1S 140758 маркийн 1ш, MAXXFORCE маркийн 1ш ус өргөх цуглуулах, сэлбэх насосууд суурилуулсан

2.5. *Хаягдал усны хэмжээ*: Үйлдвэрлэлээс гарах технологийн усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ Хаягдал усны стандарт (MNS-4943:2011)-ын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.6. *Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ*:

2.7. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин*: Ахуйн бохир усыг уурхайн тосгоны хашаанд байрлах сувагт шингээн зайлуулна. Технологийн хэрэгцээнд ашигласан усыг тунгаагуур буюу ажлын нууранд тунгааж эргүүлэн ашиглана.

2.8. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ*: Усны тухай хуулийн 13.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Туул голын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажилд 1.5 сая төгрөг зарцуулна.

2.9. *Усны тоолуур*: Усны тоолууртай.

2.10. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ*:

2.10.1. Урьдчилсан байдлаар үйлдвэрлэлийн хэрэгцээнд нөхөн сэлбэлтээр ашиглах 225'280 м<sup>3</sup> ус ашиглах төлбөрт 53'749'555 төгрөг, нөхөн сэргээлт, ногоон байгууламжинд болон зам, талбайн усалгаанд 3964 м<sup>3</sup> ус ашиглах төлбөрт 272'578 төгрөг, нийт 54'022'133 төгрөгийг Булган аймгийн Төрийн сан банкны 040000944 тоот дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

2.10.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ ус ашиглуулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр тооцож, тоолуурын заалтын дагуу орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

### Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.1. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 10 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцөлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ "ГБНБ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ТӨЛӨӨЛЖ:


Ус ашиглалтыг зохицуулах албаны  
дарга

 /Ю.Сувдимэг/


"ГБНБ" ХХК-ийн Хуулийн зөвлөх

/П.Очирлаа/

Мэдээлэл, хяналт үнэлгээний албаны  
дарга

 /Б.Оюунболд/

Геологич

 /Д.Жамбал/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул  
уурхай, эрчим хүчний ус ашиглалт  
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /С.Сүхбат/

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
20-р хороо, Гацуурт компаний байр,  
Харилцах утас: 70003357, 99035707

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,  
2-р хороо, Чингүнжавын гудамж,  
Туул голын сав газрын захиргааны  
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө  
Харилцах утас: 363716, 363714, 362592